



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Баянхутаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХЭА-2023/53/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чингис хот 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар Утас: 70562112      Цахим хаяг: <a href="mailto:Khentii@audit.gov.mn">Khentii@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390      Цахим хаяг: <a href="mailto:oyuntuyad@audit.gov.mn">oyuntuyad@audit.gov.mn</a> Аудитор: Б.Дэлгэрмаа Утас: 90109012      Цахим хаяг: <a href="mailto:platinumprogessaudit@gmail.com">platinumprogessaudit@gmail.com</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

᠒᠐᠒3.02.13 № 31  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНХУТАГ  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Г.БАТБАЯР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Баянхутаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Хэнтий аймгийн Баянхутаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангаар дансны үлдэгдэл 44,127.5 төгрөг, бараа материал 86,735.1 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,003,968.6 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй, тайлант оны үр дүн 6,343.5 мянган төгрөг байна. Тайлант онд улсын төсвөөс 455,920.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 167,656.8 мянган төгрөг, нийт 623,577.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 573,471.9 мянган төгрөгийг зарцуулж, 5,977.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар алдаа зөрчилтэй материаллаг асуудал илрээгүй.

### Бусад асуудлын хэсэг

1. Санхүүгийн тайланг хуулийн хугацаа хоцроож ирүүлсэн асуудлыг анхаарах шаардлагатай.

232310035

2. Тайлант оны санхүүгийн тайлан дахь өмнөх оны үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд тусгагдсан дүн нь аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй тусгагдсан байна. Иймд санхүүгийн программын хэрэглээг сайжруулахад анхаарч ажиллах нь зүйтэй.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>56,766,281.44</b>	<b>130,940,066.46</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	44,127,473.18
<b>311</b>	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
<b>312</b>	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	44,127,473.18
<b>3121</b>	Төгрөг	-	44,127,473.18
31211	Төрийн сангийн харилцах	-	44,127,473.18
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	38,587.40	77,505.40
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	29,500.00	39,074.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	9,087.40	38,431.40
3351	Байгууллагаас авах авлага	9,087.40	38,431.40
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	56,727,694.04	86,735,087.88
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	210,000.00	36,600.00
35130	Эм боох материал	210,000.00	36,600.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	53,767,694.04	83,948,487.88
35410	Бичиг хэргийн материал	1,821,895.00	1,387,918.00
35420	Аж ахуйн материал	35,300,739.00	60,639,870.00
35430	Сэлбэг хэрэгсэл	450,000.00	930,000.00
35450	Барилгын засварын материал	2,195,365.00	4,468,500.00
35460	Хүнсний материал	531,189.80	423,459.40
35470	Бусад хангамжийн материал	13,468,505.24	16,098,740.48
35600	Мал амьтад	2,750,000.00	2,750,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,071,769,415.46</b>	<b>1,003,968,565.11</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,071,769,415.46	1,003,968,565.11
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,064,887,415.46	997,086,565.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	998,753,068.00	998,753,068.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(74,778,198.13)	(112,399,971.63)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,114,762.11	134,609,762.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,197,928.29)	(83,913,792.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,575,656.81	52,505,656.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,500,894.96)	(21,476,002.42)
39214	Бусад үндсэн хөрөнгө	35,032,740.00	35,032,740.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,776,728.28)	(6,689,833.36)
39217	Ном	664,938.20	664,938.20
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6,882,000.00	6,882,000.00
39301	Програм хангамж	730,000.00	730,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(730,000.00)	(730,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,882,000.00	6,882,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,128,535,696.90</b>	<b>1,134,908,631.57</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,782,917.00</b>	<b>30,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,782,917.00	30,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,782,917.00	30,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,782,317.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	600.00	30,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	600.00	30,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,126,752,779.90</b>	<b>1,134,878,631.57</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,126,752,779.90	1,134,878,631.57
51101	Өмч: - төрийн	262,543,991.52	262,543,991.52
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(103,752,193.00)	(95,626,341.33)
51210	Өмнөх үеийн үр дүн	(103,752,193.00)	(101,969,876.00)
51220	Тайлант үеийн үр дүн	-	6,343,534.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	967,960,981.38	967,960,981.38
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,128,535,696.90</b>	<b>1,134,908,631.57</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>606,301,071.55</b>	<b>652,356,185.24</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,772,871.55</b>	<b>28,778,885.24</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,772,871.55	28,778,885.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,772,871.55	28,778,885.24
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,772,871.55	28,778,885.24
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>604,528,200.00</b>	<b>623,577,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	466,671,700.00	455,920,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	455,920,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	466,671,700.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,642,700.00	-
131104	Дэд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,490,300.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,152,400.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	130,213,800.00	167,656,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	130,213,800.00	167,656,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>562,507,333.13</b>	<b>646,012,650.57</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>562,507,333.13</b>	<b>646,012,650.57</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	506,611,627.87	619,267,812.58
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	278,521,387.00	332,565,652.52
210101	Үндсэн цалин	234,401,174.00	239,458,445.52
210102	Нэмэгдэл	44,120,213.00	67,784,613.00
210104	Урамшуулал	-	8,943,397.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	16,379,197.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,828,588.13	41,958,218.25
210201	Тэтгэврийн даатгал	23,469,529.53	28,574,638.83
210202	Тэтгэмжийн даатгал	2,777,622.30	3,380,004.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,909,586.24	2,668,382.49
210204	Ажилгүйдлийн даатгал	515,622.68	664,230.20
210205	Эрүүл мэндийн даатгал	5,156,227.38	6,670,962.23
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	121,789,434.33	140,832,884.26
210301	Гэрэл, цахилгаан	2,581,014.33	4,123,147.26
210302	Түлш, халаалт	117,670,920.00	134,402,137.00
210303	Цэвэр, бохир ус	1,537,500.00	2,307,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,769,401.45	4,899,697.00
210401	Бичиг хэрэг	217,851.45	1,905,647.00
210402	Тээвэр, шатахуун	1,301,550.00	971,000.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	93,500.00	-
210404	Ном, хэвлэл	268,600.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	45,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,842,900.00	2,023,050.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,287,641.60	7,697,918.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	258,900.00	200,400.00
210502	Хоол, хүнс	3,603,841.60	7,415,118.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	424,900.00	82,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,761,875.00	2,329,665.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	102,990.00	-
210604	Урсгал засвар	7,658,885.00	2,329,665.00
<b>2107</b>	<b>Томилдолт, зочны зардал</b>	1,205,000.00	-
210702	Дотоод албан томилолт	1,205,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,550,300.00	1,792,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	8,830,300.00	230,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,562,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	45,898,000.36	87,191,377.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	410,000.00	8,593,995.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,752,230.00	5,371,532.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрөгдол	38,735,770.36	73,225,850.35
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	55,895,705.26	26,744,837.99
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,498,214.00	20,766,939.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,070,508.00	16,090,439.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,427,706.00	4,676,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	14,850.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,850.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	4,388,985.67	5,977,898.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,388,985.67	5,977,898.99
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	40,993,655.59	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,993,655.59	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>43,793,738.42</b>	<b>6,343,534.67</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>43,793,738.42</b>	<b>6,343,534.67</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>604,528,200.00</b>	<b>623,577,300.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>604,528,200.00</b>	<b>623,577,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	466,671,700.00	455,920,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	455,920,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлдгээс санхүүжих	466,671,700.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,642,700.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,490,300.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,152,400.00	-
131106	Төсвийн урамшуулал	-	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	130,213,800.00	167,656,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	130,213,800.00	167,656,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>582,480,300.00</b>	<b>579,449,826.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>582,480,300.00</b>	<b>579,449,826.82</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>525,845,338.94</b>	<b>556,871,670.83</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	276,673,485.99	334,302,096.58
210101	Үндсэн цалин	157,447,717.99	239,634,706.58
210102	Нэмэгдэл	93,893,792.50	67,882,349.00
210104	Урамшуулал	24,495,090.50	10,405,844.00
210105	Гэрээт ажлын хөлс	836,885.00	16,379,197.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,984,316.62	40,185,348.19
210201	Тэтгэврийн даатгал	23,625,258.02	27,378,005.55
210202	Тэтгэмжийн даатгал	2,777,622.30	3,235,945.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,909,586.24	2,339,752.60
210204	Ажилгүйдлийн даатгал	515,622.68	848,800.97
210205	Эрүүл мэндийн даатгал	5,156,227.38	6,382,843.79
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	181,080,114.33	140,832,884.26
210301	Гэрэл, цахилгаан	2,581,014.33	4,123,147.26
210302	Түлш, халаалт	176,961,600.00	134,402,137.00
210303	Цэвэр, бохир ус	1,537,500.00	2,307,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,825,979.00	144,500.00
210401	Бичиг хэрэг	107,500.00	-
210402	Тээвэр, шатахуун	945,000.00	-
210403	Шуудан, холбоо, ингэрнэгийн төлбөр	93,500.00	-
210404	Ном, хэвлэл	46,630.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,633,349.00	144,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,377,548.00	11,520,069.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	186,400.00	-
210502	Хоол, хүнс	3,462,448.00	11,520,069.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	728,700.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,852,650.00	2,104,300.00
210604	Урсгал засвар	3,852,650.00	2,104,300.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	1,205,000.00	-
210702	Дотоод албан томилолт	1,205,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,550,300.00	3,578,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,830,300.00	230,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,347,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,295,945.00	24,204,272.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	410,000.00	18,917,742.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,885,945.00	5,286,530.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>56,634,961.06</b>	<b>22,578,155.99</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	11,237,469.80	16,600,257.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,738,013.80	11,923,757.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,499,456.00	4,676,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	14,850.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,850.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	4,388,985.67	5,977,898.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,388,985.67	5,977,898.99
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	40,993,655.59	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,993,655.59	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>22,047,900.00</b>	<b>44,127,473.18</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>22,047,900.00</b>	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>22,047,900.00</b>	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	22,047,900.00	-
222001	Тоног төхөөрөмж	20,587,900.00	-
223001	Бусад хөрөнгө	1,460,000.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(22,047,900.00)</b>	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	44,127,473.18
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	44,127,473.18

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	262,618,469.00	967,960,981.38	(103,837,270.48)	1,126,742,179.90
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	262,543,991.52	967,960,981.38	(103,752,193.00)	1,126,752,779.90
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	262,543,991.52	967,960,981.38	(103,752,193.00)	1,126,752,779.90
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	262,543,991.52	967,960,981.38	(103,752,193.00)	1,126,752,779.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	262,543,991.52	967,960,981.38	(101,969,876.00)	1,128,535,096.90
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	6,343,534.67	6,343,534.67
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	262,543,991.52	967,960,981.38	(95,626,341.33)	1,134,878,631.57

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	630,073,000.00	573,471,927.83
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	630,073,000.00	573,471,927.83
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	607,717,000.00	556,871,670.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	373,303,600.00	334,302,096.58
210101	Үндсэн цалин	255,081,300.00	239,634,706.58
210102	Нэмэгдэл	85,851,300.00	67,882,349.00
210104	Урамшуулал	9,666,000.00	10,405,844.00
210105	Гэрээт ажлын хөлс	22,705,000.00	16,379,197.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46,095,300.00	40,185,348.19
210201	Тэтгэврийн даатгал	31,344,900.00	27,378,005.55
210202	Тэтгэмжийн даатгал	3,687,600.00	3,235,945.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,950,000.00	2,339,752.60
210204	Ажилгүйдлийн даатгал	737,600.00	848,800.97
210205	Эрүүл мэндийн даатгал	7,375,200.00	6,382,843.79
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	144,908,700.00	140,832,884.26
210301	Гэрэл, цахилгаан	8,200,000.00	4,123,147.26
210302	Түлш, халаалт	134,402,400.00	134,402,137.00
210303	Цэвэр, бохир ус	2,306,300.00	2,307,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	262,000.00	144,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	262,000.00	144,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	8,316,500.00	11,520,069.80
210502	Хоол, хүнс	8,316,500.00	11,520,069.80
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,104,400.00	2,104,300.00
210604	Урсгал засвар	2,104,400.00	2,104,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,614,600.00	3,578,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлб	230,400.00	230,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,384,200.00	3,347,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	29,111,900.00	24,204,272.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,111,900.00	18,917,742.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,286,530.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	22,356,000.00	16,600,257.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	22,356,000.00	16,600,257.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,679,500.00	11,923,757.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,676,500.00	4,676,500.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	630,073,000.00	617,599,401.01
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	468,394,098.99	455,920,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	468,394,098.99	455,920,500.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	161,678,901.01	161,678,901.01
132001	Орон нутгийн төсвөөс	161,678,901.01	161,678,901.01
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>44,127,473.18</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 29431.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 29431.2 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Үнэ төлбөргүй хүлээн авсан 27,648.9 мянган төгрөгийн бараа материалын орлогыг орлого, үр дүнгийн тайлан, бараа материалын тайланд зөрүүтэй илэрхийлэгдсэнийг залруулав.

2. Тооцоо нийлсэн актаар өр төлбөргүй болох нь тогтогдсон тайлан дахь өмнөх оны үлдэгдэл 1,782.3 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөрийг залруулав.

Аудитаар нийт 1,970.3 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 1739.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 231.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөв.

#### 3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### 3.2 Албан шаардлага

Цалингийн зардалтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Тайлант онд ХХОАТ-ийн хөнгөлөлтийн зөрүүг тооцоогүйгээс шалтгаалан 11 албан хаагчдад 133184 төгрөг илүү, 18 албан хаагчдад 390181 төгрөг дутуу хөнгөлөлт эдлүүлсэн мөн цалингийн дэлгэрэнгүйг нийгмийн даатгалын тайлантай тулгахад 11 ажиллагсдын цалин, шимтгэлийг 1215961 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 23.1 “Албан татвар төлөгчийн энэ хуулийн ...-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.7 “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө тусалцаа авах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

#### 3.3 Зөвлөмж

Бараа материалын зардалтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Эргэлтийн номын сангийн түрээсийн орлогыг аккурэл сууриар бүртгээгүй, түрээсээр олгосон сурах бичгийн тайлан байхгүй байгаа нь БСШУСС-ын 2019 оны А/302 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Журам, зааврыг хэрэгжүүлж ажиллах.

### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баянхутаг сумын ЕБС	1	29,431.2					1	29,431.2				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>29,431.2</b>					<b>1</b>	<b>29,431.2</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Баянхутаг сумын ЕБС	1	1,739.3			1	1,739.3						
Баянхутаг сумын ЕБС	1	231.0					1	231.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,970.3</b>			<b>1</b>	<b>1,739.3</b>	<b>1</b>	<b>231.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Баянхутаг сумын ЕБС	1	3,829.0					1	3,829.0
Баянхутаг сумын ЕБС		16,800.3				16,800.3		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>20,629.3</b>					<b>1</b>	<b>20,629.3</b>
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>20,629.3</b>					<b>1</b>	<b>20,629.3</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

